

НИЙСЛЭЛИЙН ДҮҮРГҮҮД

Төсвийн тухай, Шилэн дансны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиуд болон холбогдох журмууд нийслэлийн дүүргүүдэд дунджаар 31 хувьтай хэрэгжиж байгаа нь олон улсын жишгээр “хангалтгүй” дүн юм.

Орон нутгийн төсвийн ил тод байдлын судалгааг иргэний нийгмийн байгууллагууд болон судлаачидтай хамтран ННФ–аас хийж гүйцэтгэв.

СУДАЛГААНЫ ДҮН

ДҮҮРГҮҮДИЙН ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ, ХУВИАР

д/д	Үнэлгээний үзүүлэлтүүд	Эрх зүйн баримт бичиг	Төсвийн төсөл	ИТХ–ын хуралдаан	Батлагдсан төсөв	Иргэний төсөв	Төсвийн тодотгол	Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа	Төсвийн гүйцэтгэл	Орон нутгийн хөгжлийн сан	Засаг даргын нөөц хөрөнгө	Орон нутгийн тусгай сангууд	Хандив, тусламжийн хөрөнгийн зарцуулалт	Нэгдсэн үнэлгээ	Рейтинг
1	Налайх	25	17	31	35	0	13	42	76	8	50	75	75	37.2	Дунджаас дээш
2	Баянзүрх	26	21	34	39	0	31	39	73	8	25	50	88	36.1	
3	Баянгол	39	13	38	67	0	19	34	81	0	0	75	63	35.6	
4	Хан–Уул	19	8	28	63	0	13	27	64	4	0	75	88	32.3	Дундаж
5	Сонгинохайрхан	33	14	15	40	0	17	38	70	0	25	25	88	30.3	
6	Сүхбаатар	30	13	28	75	0	23	36	71	6	0	25	50	29.7	
7	Багануур	40	11	41	36	0	25	29	46	13	25	25	38	27.4	Дунджаас доош
8	Чингэлтэй	31	7	8	67	0	6	39	54	4	0	50	50	26.2	
9	Багахангай	39	25	10	42	0	19	33	73	21	0	0	38	24.8	
Дундаж үнэлгээ (хувь)		31.3	14.2	25.6	51.4	0.0	18.3	35.1	67.6	7.1	13.9	44.4	63.9	31.1	

31%

2016 оны байдлаар нийслэлийн 9 дүүргийн төсвийн ил тод байдлын үзүүлэлт нийт авбал зохих 100 хувиас дунджаар 31 байгаа нь дүүргүүдийн төсвийн ил тод байдал хангалтгүй байгааг харуулж байна.

Үнэлгээг 2015 оны 6 дугаар сарын 1–ээс 2016 оны 6 дугаар сарын 1 хүртэл жилийн хугацаанд төсвийн үйл явцын мэдээлэл ба баримт бичгүүдээ дүүргүүд хэрхэн ил тод болгосон байдалд үндэслэн хийж гүйцэтгэсэн болно.

Судалгааны тайланг бүрэн эхээр нь www.forum.mn цахим хуудаснаас үзнэ үү.